

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН (2025.01.01-12.20)

2025 оны 12 дугаар сарын 22

Улаанбаатар хот

Нэг. Өргөдөл, гомдлын бүртгэл, шийдвэрлэлтийн талаар:

“Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай” хууль, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1049 дүгээр захирамжаар батлагдсан “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журам”-ын дагуу иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч, холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэн, шийдвэрлэлтэд хяналт тавих, иргэнд хариу өгөх ажлыг зохион байгуулж дээд шатны байгууллагаас ирсэн үүрэг чиглэлийн дагуу 3 зорилт 10 арга хэмжээний тусгай төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Дүүргийн хэмжээнд 2025 оны байдлаар дараах эх үүсвэрүүдээс 4749 өргөдөл гомдол бүртгэгдэж, ирсэн байна. Үүнд:

- Засгийн газрын 11-11 төв- 2413 буюу 50.81%
- Нутгийн захиргааны байгууллага- 1812 буюу 38.16%
- 1800-1200 операторын утас-342 буюу 7,20%
- Хороо бүртгэсэн- 75 буюу 1.58%
- Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв- 55 буюу 1.16%
- E-Service -39 буюу 0.82%
- Дижитал сити- 6 буюу 0.13%
- НМХГ тусгай дугаар- 5 буюу 0,11%
- Онлайн бизнес төв- 1 буюу 0,02%
- Гар утасны аппликейшн- 1 буюу 0,02% тус тус ирснээс нийт өргөдлийн 2413

буюу 50,81 хувийг Засгийн газрын 11-11 төвд хандсан өргөдөл, гомдол эзэлж байна. Үүнээс хуулийн хугацаанд шийдвэрлэсэн 2387, судалж байгаа 24, хуулийн хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 2 өргөдөл байна. Засгийн газрын 11-11 төвөөр дамжуулан удаа дараа хандсан 5 иргэний өргөдлийг судлан үзэхэд өөр өөр утга агуулгаар хандсан асуудлууд байгаа бөгөөд иргэнд хариуг хууль зүйн үндэслэлтэй албан бичгээр болон зохион байгуулсан ажлын илтгэх хуудас, утсаар зөвлөгөө мэдээлэл өгч шийдвэрлэсэн байна.

Сонгинохайрхан дүүргийн хэмжээнд 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 12 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар нийт 4749 өргөдөл, гомдол, санал, хүсэлт

ирснээс хуулийн хугацаанд шийдвэрлэсэн 4654 буюу 98%, судлагдаж байгаа 91 буюу 1,92%, хуулийн хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 4 буюу 0,08 хувь байна. шийдвэрлэлтийн дундаж хугацаа 8 хоног 17 цаг 30 минут байна.

Нийт өргөдөл, гомдлыг өмнөх оны энэ үетэй харьцуулбал:

График-1



Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцад нийт 277 зөрчил гарч өдөрт нь багтаан хүлээн аваагүй 163, өдөрт нь багтаан шилжүүлээгүй 71, явцын тэмдэглэл хөтлөөгүй 43 зөрчил бүртгэгдсэн байна. Зөрчлийг өмнөх оны энэ үетэй харьцуулахад 297 буюу 6 хувиар буурсан, хуулийн хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл 4, өмнөх оны мөн энэ үед 9 буюу 55 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Иргэдээс гаргасан өргөдөл, гомдлын төрлийг өмнөх оны энэ үетэй харьцуулбал:

Хүснэгт-1

№	Хугацаа	Хүсэлт	Гомдол	Талархал	Санал	Мэдэгдэл	Нийт
Дүүргийн харьяа хэлтэс, алба							
1.	2024	2232	2746	514	75	8	5601
2.	2025	2366	1885	440	52	2	4749
Засаг даргын Тамгын газар							
1.	2024	647	1026	9	45	6	1753
2.	2025	666	633	11	22	2	1335

Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлын хуулийн хугацаа хэтрүүлч шийдвэрлэсэн 4 өргөдөл, гомдол бүртгэгдсэн бөгөөд дараах арга хэмжээг авч ажилласан. Үүнд:

Хүснэгт-2

Байгууллага	Мэргэжилтэн	Өргөдлийн дугаар	Төрөл	Огноо		Хэтэрсэн хугацаа /хоног/
				Ирсэн	Шийдсэн	
Засаг даргын Тамгын газар	Д.Мөнгөндалай	G250502226	Гомдол	2025-05-02	2025-06-03	1.922
1.Гомдлын агуулга						
СХД-ийн 30 дугаар хороо, Хилчний 3-р гудамжны 1 тоотод сургуулийн барилга баригдаж байна. Өнгөрсөн жилээс хойш энэ ажил явагдаж байна. Манай гэрийн цахилгааны шитийг шонтой хамт барилгын ажил хийж байгаа том машинууд шороогоор булчихсан байна. Цахилгааны утсыг таслаад нүх шороо асгасан тэр дээр хүүхдүүд гулсаж тоглоод цахилгааны шитийг унтрааж байна. Энэ барилгын газарт хашаа бариулах юм уу? Эсвэл манай цахилгааны шонг өөр газарт нүүлгэж өгнө үү. Холбогдох байгууллагад нь уламжилж өгнө үү.						
2.Шийдвэрлэлтийн байдал						
Дүүргийн 30 дугаар хороонд баригдаж буй сургуулийн барилга барьж буй байгууллагын захирал Гантулгын 99115304 дугаарын утсаар ярьж мэдээлэл авсан. Барилгын гадна тохижилтын ажлыг ирэх долоо хоногоос эхлүүлэхээр төлөвлөж байгаа тухайн иргэний асуудлыг эхний ээлжинд шийдвэрлэхээ мэдэгдсэн болно. Иргэний утсаар ярьж мэдээлэл өгсөн.						
3.Хугацаа хэтрүүлсэн тайлбар						
Өргөдлийг 2025 оны 05 угаар сарын 30-ны өдөр 28 хоног буюу 2 хоног дутуу байхад хаасан боловч шийдвэрлэлт шаардлага хангаагүй шалтгаанаар буцаагдаж хугацаа хэтэрсэн болно. Иргэний өргөдлийн дагуу Гүйцэтгэгч Монгол зам ХХК-тай холбоо барьж асуудлыг шийдвэрлэсэн бөгөөд талаар иргэнд утсаар хариу хүргэж ажилласан талаар тайлбар ирүүлэв.						
4.Хариуцлага тооцсон байдал						
2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн албан хаагчдыг гүйцэтгэлийг үнэлэх үнэлгээний хороо Засаг даргын Тамгын газарт 3-с дээш зөрчил гаргасан 2 албан хаагч, хуулийн хугацаа хэтрүүлсэн 1 албан хаагчийн тайлангийн үнэлгээнээс бууруулан, хариуцлага тооцсон.						

Хүснэгт-3

Байгууллага	Мэргэжилтэн	Өргөдлийн дугаар	Төрөл	Огноо		Хэтэрсэн хугацаа /хоног/
				Ирсэн	Шийдсэн	
27-р хороо	Б.Нямхишиг	H250616002	Гомдол	2025-06-16	2025-07-25	8.916
1.Гомдлын агуулга						
ХХҮХ-ийн мэргэжилтэн Нямцэцэг нь Ю-Мони ТҮЦ-ийг 27 дугаар хорооны Засаг даргын танил найз, хүүхдийн баяраар бэлэг сэлт авч ажилладага, зөвшөөрөл олгосон гэх цуу яриа дүүрэг хороогоор яриж нэр хүндэд сөргөөр нөлөөлж байгаа туд арга хэмжээ авч өгнө үү.						
2.Шийдвэрлэлтийн байдал						
Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст албан бичгээр хүргүүлсэн.						
3.Хугацаа хэтрүүлсэн тайлбар						
2025.06.16-ны өдөр ERP системд өргөдөл бүртгэсэн. 2025.07.24-ний өдөр Зохион байгуулагчид шилжүүлж, 07 дугаар сарын 25-ны өдөр шийдвэрлэж хугацаа хэтрүүлсэн. Тайлбар ирүүлээгүй.						
4.Хариуцлага тооцсон байдал						
Дүүргийн Засаг даргын Тамгын газрын Б/276 дугаар тушаалаар сахилгын шийтгэл ноогдуулсан. Албан хаагчдын сахилга, хариуцлага дэг журмыг сайжруулахаар арга хэмжээ авч ажиллаж байна.						
 27 хороо Б.Нямхишиг сахилг.		 img07012025_0002. pdf				

Хүснэгт-4

Байгууллага	Мэргэжилтэн	Өргөдлийн дугаар	Төрөл	Огноо		Хэтэрсэн хугацаа /хоног/
31-р хороо	Д.Отгонцэцэг	G250617122	Гомдол	2025-06-17	2025-07-22	4.978
1.Гомдлын агуулга						
СХД-ийн 31-р хорооны иргэн байна. Зам дагуу далангийн ажил явуулахдаа явган хүний зам биш дугуйн зам гаргана гэж хэлсэн ч, бодит байдал дээр айлуудын замыг хаагаад байна. Мөн гал команд, түргэний тэрэг, ус, хогийн машин зэрэг тээврийн хэрэгслүүд орох боломжгүй болгож байна. Холбогдох байгууллагад нь уламжилж өгнө үү.						
2.Шийдвэрлэлтийн байдал						
Холбогдох байгууллагад уламжилсан албан бичгээр шийдвэрлээгүй хавсаргаад орхисон.						
3.Хугацаа хэтрүүлсэн тайлбар						
2025 оны ээлжийн амралтаа авсан байх хугацаанд орлон ажиллаж байсан Нийгмийн ажилтан хугацаа хэтрүүлсэн талаарх тайлбар ирүүлсэн.						
4.Хариуцлага тооцсон байдал						
Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга зөрчил гаргасан хороодын зохион байгуулагч, нийгмийн ажилтан нартай уулзаж хамт олон дунд хатуу анхааруулсан. Тухайн үед орлон ажиллаж байсан нийгмийн ажилтанд эхний удаа анхааруулга өгч, цаашид анхаарч ажиллахыг мэдэгдсэн.						

Хүснэгт-5

Байгууллага	Мэргэжилтэн	Өргөдлийн дугаар	Төрөл	Огноо		Хэтэрсэн хугацаа /хоног/
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	Ц.Азжаргал	O250617125	Хүсэлт	2025-06-17	2025-07-18	0.969
1.Гомдлын агуулга						
Буцалтгүй тусламж хүсэх тухай.						
2.Шийдвэрлэлтийн байдал						
Сонгинохайрхан дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хөдөлмөрийн дотоод журмын 8 дугаар зүйлийн 8.1.5-т заасны дагуу 3 жилээс дээш хугацаагаар тасралтгүй ажилласан албан хаагчид олгох тул өөр байгууллагад ажиллаж байгаад 2025 онд төрийн үйлчилгээний албан хаагчаар орсон тул одоогоор шийдвэрлэх боломжгүй байна.						
3.Хугацаа хэтрүүлсэн тайлбар						
Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу материалын бүрдлийг ханган авч, дээд албан тушаалтанд уламжлан ажилласан. Мөн 2025 оны 7 дугаар сарын 16-17-ны өдрийн нийтээр амрах өдөр болгосон тул хугацаа хэтрээгүй болно.						
4.Хариуцлага тооцсон байдал						
Тамгын газрын 03/2680 дугаартай албан бичгийг хүргүүлж ажилласан. <u>Хариу тайлбар</u> : Засгийн газрын хуралдаанаар /2025.06.04/ Үндэсний их баяр наадам, Ардын хувьсгалын ойн баярын өдрүүдийн 12, 13-ны өдөр нь Бямба, Ням гарагт тохиож байгаа тул 2025 оны 7 дугаар сарын 16, 17-ны өдрийн Лхагва, Пүрэв гарагт ажилтан, албан хаагчдыг амраах зохицуулалт хийж, амраасан тул энэ амралтын хоногийг өргөдөл гомдлын шийдвэрлэх хугацаанд хамаарсан байна гэх тайлбар ирүүлсэн бөгөөд албан хаагчдад хариуцлага тооцоогүй байна.						

Өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцад нийт 277 зөрчил гарснаас дэргэдэх харьяа байгууллагын зөрчлийн дэлгэрэнгүйг авч үзвэл:

Хүснэгт-6

№	Хэлтэс, алба нийт зөрчил	Зөрчил гаргасан албан хаагч	Нийт ирсэн Өргөдлийн тоо	Зөрчлийн тоо	Зөрчлийн төрөл			
					Өдөрт нь багтаан шилжүүлээгүй	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй	Явцын тэмдэглэл хөтлөөгүй	Буцаалтыг 3 хоногт багтаан хийгээгүй
1	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал-4	Э.Түмэндэлгэр	90	4	4			
2	Насан туршийн суралцахуйн төв-6	3.Батцэцэг	5	6	6			
3	Боловсролын хэлтэс-15	Б.Бадамханд	225	15		7	1	
4		Б.Март				2	2	
5		Б.Отгонсүрэн					1	
6		Х.Энхсаруул					2	
7	Газар зохион байгуулалтын алба-9	Б.Бат-Оргил	474	9			2	
8		Ч.Бадамханд					1	
9		Б.Лхавгадэмбэрэл					5	
10		Н.Соёл-Эрдэнэ					1	
11	Нийгмийн даатгалын газар-6	Л.Түвшин	345	11	2	3		
		И.Гүнсоёл			3			
12		О.Баярсайхан					1	
13		О.Нямсүрэн					1	
14		А.Энхцэцэг						1
15	Худалдан авах ажиллагааны алба-3	Г.Бадамрэнчин	1	3		3		
16	Цагдаагийн 1 дүгээр хэлтэс	Г.Анужин	153	2		2		
17	Цагдаагийн 2 дугаар хэлтэс	Б.Оюун-Эрдэнэ	89	1		1		
18	Цагдаагийн газар	Х.Ууганбаяр	1	1		1		
19	Улсын бүртгэлийн хэлтэс-8	Г.Цэцэгдулам	121	8	2	5	1	
20	Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын хэлтэс	С.Одгэрэл	223	4			1	
21		Б.Халиунаа				1		
22		А.Долгосүрэн				2		

23	Захиалагчийн ажлын алба ОНӨААТҮГ	Ч.Номундарь	21	3		2		
24		С.Эрдэнэбаяр				1		
25	Тохижилт цэвэрлэгээ үйлчилгээ ОНӨААТҮГ	С.Бархасбуд	8	1		1		
26	Нэгдсэн эмнэлэг-9	Н.Хайруул	516	9		1		
27		Б.Сүхтулга				6		
28		Э.Орхонсүрэн				1		
29		Г.Алтанцэцэг				1		
30	Эрүүл мэндийн төв	О.Сугарсүрэн	302	1		1		
31	Жижиг дунд үйлдвэрийг дэмжих мэдээлэл сургалтын төв	Х.Эрдэнэтуяа	1	6		6		
32	НЕБ-ын 107 дугаар сургууль	Д.Мөнхзаяа	1	1		1		
33	НЕБ-ын 294 дүгээр цэцэрлэг	Д.Оюунтүлхүүр	5	8	8			
34	НЕБ-ын 121 дүгээр сургууль	Б.Дуламсүрэн	12	1		1		
Нийт		34	2593	94	25	43	25	1

Засаг даргын Тамгын газрын хороодын зөрчлийн дэлгэрэнгүйг авч үзвэл;

Хүснэгт-7

№	Хороо	Зөрчил гаргасан албан хаагч	Нийт ирсэн өргөдөл	Нийт зөрчлийн тоо	Зөрчлийн төрөл		
					Өдөрт нь багтаан шилжүүлээгүй	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй	Явцын тэмдэглэл хөтлөөгүй
1	27-р хороо	Я.Энхдолгор	10	23	21		
		Б.Нямхишиг			1	1	
2	7-р хороо	С.Нямдорж	4	15		15	
3	30-р хороо	Б.Мөнхзаяа	6	12		12	
4	21-р хороо	Түмэнзаяа	9	12	4	8	
5	38-р хороо	Б.Гантуул	5	13	10		
		О.Баяржаргал				1	2
6	43-р хороо	Л.Батдорж	6	10		9	1
7	19-р хороо	Б.Нямтайван	14	5	1	1	
8		Д.Отгонбурам				2	1

9		Р.Батчулуун				8	
10	25-р хороо	Б.Сэвжидсүрэн	3	9			1
11	34-р хороо	В.Туул	12	7		7	
12	15-р хороо	Р.Оюун-Отгон	12	7		7	
13	20-р хороо	Я.Чулуунхүү	9	6		6	
14	35-р хороо	Ц.Алтантана	1	5		5	
15	17-р хороо	Ж.Энхмаа	9	3		3	
16	42-р хороо	Б.Цэрэндулам	4	2		2	
17	41-р хороо	Н.Энжаргал	5	2		2	
18	24-р хороо	Н.Зоригтбаатар	7	2	2		
19	12-р хороо	Д.Соёлмаа	2	1		1	
20	11-р хороо	Э.Должинсүрэн	10	1		1	
21	9-р хороо	Б.Гэрэлчулуун	2	1		1	
22	26-р хороо	А.Дуламсүрэн	3	1		1	
23	3-р хороо	Д.Нандин- Эрдэнэ	6	1		1	
24	37-р хороо	О.Эрдэнэгэрэл	28	1		1	
Нийт			158	139	39	95	5

Засаг даргын Тамгын газрын өргөдөл, гомдол шийдвэрлэх явцад гарсан зөрчлийн дэлгэрэнгүйг авч үзвэл;

Хүснэгт-8

№	Хэлтэс, тасаг	Зөрчил гаргасан албан хаагч	Нийт ирсэн өргөдөл	Нийт зөрчлийн тоо	Зөрчлийн төрөл		
					Өдөрт нь багтаан шилжүүлэ эгүй	Өдөрт нь багтаан хүлээн аваагүй	Явцын тэмдэглэл хөтлөөгүй
1	Удирдлага	Ц.Баттөр	-	6	1	5	
2		Д.Баярсайхан	2	1		1	
3	Төрийн захиргааны удирдлагын хэлтэс	М.Мандаарий	76	7			1
4		Г.Нарангарав	35			2	
5		Б.Номин-Эрдэнэ	9		3	1	
6	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс	Р.Мөнхтуяа	182	6			4
7		Ц.Шинэхүү	64				1
8		Ц.Саруул	18			1	
9	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс	Ц.Бямбацолмон	59	6		1	3
10		Ч.Ариунтунгалаг	26			1	
11		Д.Цэдэнсүрэн	5			1	
12	Аж ахуйн тасаг	Б.Анхзаяа	4	4		4	
13		Ц.Гэрэлмаа	33	3		1	

14	Агаарын бохирдолтой тэмцэх тасаг	И.Оюунгэрэл	68				1
15		Ц.Балжинням	4				1
16	Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэс	А.Батсайхан	4	5		3	
17		Ө.Норовдэмид	14				1
18		Д.Мөнгөндалай	20				
19	Нийгмийн хөгжлийн хэлтэс	Т.Баярмаа	169	3	3		
20	Ханалт- шинжилгээ үнэлгээний хэлтэс	С.Туулмаа	4	2		2	
21	Хөдөө аж ахуйн тасаг	С.Мижиддорж	19	1		1	
Нийт			642	44	7	25	12

Дүүргийн хэмжээнд нийт зөрчлийн 163 буюу 58,8%-ийг өдөрт нь багтаан хүлээн аваагүй зөрчил тэргүүлж байна. Зөрчил гаргасан албан хаагчаас хариу тайлбар авахад (гадуур ажилтай байсан, тог тасарсан, сургалттай байсан) гэх мэт шалтгаан дурдсан байна. Өргөдөл, гомдлын мэдээг дүүргийн удирдах албан тушаалтны шуурхай хуралд танилцуулж, өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд зөрчил дутагдал гаргасан албан тушаалтнаас хариу тайлбар авч, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 7 хоног бүр хүргүүлж ажилласан. Тус ажлын хүрээнд удаа дараа зөрчил дутагдал гаргасан, систем ашиглалтыг сайжруулж ажиллахгүй байгаа нийт 9 байгууллагын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийж, Засаг даргын Тамгын газрын 03/276, 03/475, 03/770, 03/1200, 03/1201, 03/1212, 03/1213, 03/2324, 03/2680, 03/2690-2694, 03/2698-2704, 03/2771, 03/3388 03/276, 03/475, 03/770 , 03/1200, 03/1201, 03/1212, 03/1213 дугаартай албан бичгээр чиглэл хүргүүлсэн.

Хоёр. Гомдлыг бууруулах чиглэлээр:

Дүүргийн хэмжээнд 1885 гомдол ирснээс өмнөх оны мөн энэ үетэй харьцуулахад 2746 буюу 31,4 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Нийт гомдлын 633 буюу 33,6 хувь нь Засаг даргын Тамгын газарт ирснээс дараах 5 хандалт тэргүүлж байна. Үүнд:

1. Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн болон ТҮЦ, павильон, ил задгай худалдаа, үйлчилгээний тухай 52 буюу 8.27%
2. Нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилтын тухай 45 буюу 7,15%
3. Хороодын үйл ажиллагааны тухай 45 буюу 7.15%
4. Хог цэвэрлэгээ, тээвэрлэлтийн тухай 43 буюу 6.84%
5. Явган хүний зам, талбайн тохижилтын тухай 24 буюу 3.82%

2.1) Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн болон ТҮЦ, павильон, ил задгай худалдаа, үйлчилгээний чиглэлээр;

Нийтийн эзэмшлийн зам талбай, ил задгай худалдааны чиглэлээр ирүүлсэн гомдолд дүн шинжилгээ хийж агуулгыг нэг бүрчлэн судлан үзэхэд (нийтийн эзэмшлийн зам талбайд зөвшөөрөлгүй ил задгай худалдаа эрхэлж байгаа асуудлаар, ТҮЦ зөвшөөрөлгүй байршуулсан байна буулгуулах тухай, ил задгай мах, хүнсний бүтээгдэхүүн ил задгай борлуулж байна шалгаж өгнө үү, хүнсний эрүүл ахуйн асуудал алдагдаж байгаа тухай) гомдлууд эзэлж байна.

Дүүргийн 27, 37-р хорооны нутаг дэвсгэрийн автобусны буудлын ойр орчимд ил задгай худалдаа эрхлэгчид нь нийтийн эзэмшлийн талбай, явган хүний зам дээр зогсож, зорчигчдын хөдөлгөөнд саад болох, орчны хог хаягдал бохирдлыг их үүсгэдэг, шороо тоос, автомашины утааны бохирдол ихтэй орчинд хүнсний аюулгүй байдал алдагдуулсан хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхүйц бараа бүтээгдэхүүн худалдаалдаг зэрэг зөрчлүүд гарч иргэдээс удаа дараа гомдол ихээр ирж байгаа тул гомдлын мөрөөр худалдаа эрхлэгчдийг шалгах, үйл ажиллагааг зогсоох ажлын хэсэг байгуулагдаж, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж арга хэмжээ авч ажилласан.



Нийслэл, дүүргийн Засаг даргын захирамжийн хүрээнд дүүргийн Газар зохион байгуулалтын алба, Дэд бүтцийн хөгжлийн алба, Захиалагчийн алба, хороо, дүүргийн холбогдох газар хэлтэс, мэргэжилтнүүд хамтран дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 12, 13, 14, 15, 17, 18, 19, 20, 27, 29, 32, 37 дугаар хороодын нийтийн эзэмшлийн талбай, автобусны буудлууд дахь ТҮЦ-ийг буулгах, нүүлгэн шилжүүлэх ажлыг зөвшөөрөлгүй барьсан хашаа, хайс, гарааш, хаягийн байгууламжийг буулгаж нийтийн эзэмшлийн зам талбайг чөлөөлж орц гарцыг нээх ажлыг зохион байгуулсан. Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 9 байршилд 81 ТҮЦ, 12 байршилд 81 зар сурталчилгааны самбарыг буулгаж явган хүний орц гарцыг нээгээд байна.

Мөн нийтийн эзэмшлийн зам талбайд зөвшөөрөлгүй байршуулсан гараашийг буулгаж 100 гаруй автомашины зогсоол барьж нийтэд чиглэсэн ажлыг хэрэгжүүлсэн. Цаашид энэ ажлыг эрчимжүүлж нийтийн эзэмшлийн зам талбайг хашаалсан хашаа хайс, хаягийн байгууламжийг буулгах ажлыг үе шаттай зохион байгуулж ажиллахаар төлөвлөөд байна.



ТҮЦ эрхлэгч иргэдийн төлөөлөлтэй уулзаж ажлын байранд зуучлах, өөр байршил об'ектод худалдаа эрхлэх хүсэлтийг судалж, 10 иргэнийг Драгон худалдааны төвд түрээсийн хөнгөлөлт, уян нөхцөлтэй гэрээ байгуулж ажиллаж байна.

Дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжид “Хүнсний хангамж, аюулгүй байдал”, салбарт хэрэгжиж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийн явц, нөхцөл байдлын талаар мэдээлэл хүргэж тулгамдаж буй асуудлаар санал бодлоо солилцон, зөвлөн туслах, мэргэжил арга зүй зөвлөгөөг Татварын хэлтэс, Хүнс худалдаа үйлчилгээний хэлтэс хамтран сургалт зохион байгууллаа. Сургалтад 112 аж ахуйн нэгжийн төлөөллүүд хамрагдсан.

2.2) Хороодын үйл ажиллагааны чиглэлээр;

Хороодын үйл ажиллагаатай холбоотой ирсэн гомдлын тэргүүлэх агуулгад (2, 5, 21, 22, 33, 34, 40, 42, 43-р хороо хүнд сурталтай байна. Иргэдэд түргэн шуурхай үйлчилгээ үзүүлэхгүй иргэнийг олон дахин явуулж байна, хороо эзэнгүй, Засаг дарга нь ажил дээрээ байхгүй байгаа тухай, халамжийн үйлчилгээг хорооноос авах байсныг нааш цааш явуулж чирэгдүүлж байгаа тухай, хорооны тодорхойлолт авахад олон бичиг баримт шаардаж байна, хорооны түр оршин суугаа тодорхойлолт авахад маш хүндрэлтэй байна, хорооны ажилтнуудын ажлын чанарыг сайжруулж өгөх) зэрэг тус тус гомдлууд тэргүүлж байна.

(Хорооны албан тушаалтны ёс зүйтэй холбоотой ирсэн гомдлын тэргүүлэх хандалтад 3, 14-2, 19, 21, 23, 35-3, 40-р хорооны Засаг дарга харилцаа хандлага, ёс зүйгүй байна. Хорооны Засаг дарга ажлын байрны дарамт үзүүлж, хэл амаар доромжилсон талаар, 2-3, 11, 16-р хорооны хэсгийн ахлагч ажлын байрандаа байхгүй байна, харилцаа хандлага муу, ёс зүйгүй, төрийн үйлчилгээ болон хог ачилтын талаар мэдээлэл өгөхгүй байгаа тухай, иргэнийг хэл амаар доромжилж, ёс зүйгүй хандсан асуудлыг шалгаж өгнө үү) зэрэг гомдол тэргүүлж байна.

Хороодын өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт тавьж, гомдлын тэргүүлэх хандалтад дүн шинжилгээ хийж Засаг дарга нарын шуурхай хурал дээр өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн мэдээ, зөрчил дутагдлыг танилцуулсан. Хурлаас гарсан удирдлагын шийдвэрийн дагуу тухайн зөрчил дутагдлыг арилгах, ажлыг сайжруулах талаар үүрэг чиглэл хүргүүлж, эхний байдлаар анхааруулга өгсөн. Цаашид удаа дараа зөрчил дутагдал давтагдсан тохиолдолд хуулийн дагуу арга хэмжээ авч ажиллах болохыг мэдэгдсэн болно.

Дүүргийн хэмжээнд албан хаагчдын ёс зүй, авлига ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх чиглэлээр үе шаттай төлөвлөгөөт сургалтуудыг зохион байгуулснаас гадна хороодын 41 албан хаагч нарт өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, тогтоомж болон өргөдлийг бүртгэх, шийдвэрлэх, систем ашиглах арга зүйн сургалтыг зохион байгуулсан. Өргөдөл, гомдлыг хүлээж авах, шилжүүлэх, явцын тэмдэглэл хөтлөх заавар зөвлөгөөг давхардсан тоогоор 120 гаруй албан хаагч нартай биечлэн болон утсаар зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.



Төрийн анхан шатны үйлчилгээг хороодын албан хаагчид иргэдэд хамгийн түрүүнд хүргэдэг. Иймд хороодын нийгмийн ажилтан, хэсгийн ахлагч нарын хүний эрхийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүний эрхэд суурилсан төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор “Хүний эрхэд суурилсан төрийн үйлчилгээ” сургалт зохион байгуулсан.



Нийтийн соёлын талаар баримтлах бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд үйлчилгээний стандартыг сайжруулах, үйлчилгээний соёлыг нэвтрүүлэх, түргэн шуурхай, соёлтой үйлчилгээг хэвшүүлэх, хотын соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор жил бүр уламжлал болгон “Соёлтой сонгинохайрханчууд-3” аян зохион байгуулдаг. Энэ хүрээнд дүүргийн Засаг даргын Тамгын газар, Соёлын ордон, 16 дугаар хороо хамтран “Нийтийн соёлыг нэмэгдүүлэхэд бидний оролцоо” сэдэвт сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулсан.



2.3) Нийтийн эзэмшлийн зам, талбайн тохижилтын чиглэлээр;

(Нийтийн эзэмшлийн зам талбай болон тоглоомын талбайн эвдрэл, гэрэлтүүлэг асахгүй байгаа тухай, өдрийн цагаар гэрэлтүүлэг ажиллаж байгаа тухай, чөлөөлсөн талбайн тохижилтын асуудлаар, цахилгаан шон хазайсан, ил задгай утасны асуудлаар) хандалтууд тэргүүлээд байна. Тус ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Дүүргийн “Дэд бүтцийн хөгжлийн алба” ОНӨААТҮГ нь дүүргийн 6,10,13,14, 41 дүгээр хороонд хөл бөмбөгийн талбайг сэргээн засварлаж, талбайн дэргэд лега шалтай, бялдаржуулах төхөөрөмж, ширээн теннисний ширээг байрлуулж, зарим хороодод шинээр тоглоомын талбайг байгуулаад байна.



Иргэдийн гомдол, хүсэлтийн дагуу дүүргийн 1 дүгээр хороо, толгойтын 91 дүгээр гудамжинд шинээр 0.482 км авто замын ажлыг хийж, 38 дугаар хороонд Updown хотхонд 450 м2 талбайд 60 тн асфальт, хучилт хийж орц, гарц гаргасан.

35-р хороонд 1,4 км урттай авто зам, 32-р хороонд 2,6 км авто замын ашиглалтад оруулаад байна. Нутаг дэвсгэрийн хэмжээнд жил бүр тулгардаг зун нь үер, өвөл нь халиа дошин үүсдэг айл өрхийг нүүлгэн, шилжүүлэх газар чөлөөлөлтийн ажлыг эхлүүлж нийтийн эзэмшлийн зам талбайг тохижуулах, бүтээн байгуулалтыг олон ажлыг энэ онд багтаан хэрэгжүүлээд байна.



2.4) Хог цэвэрлэгээ, тээвэрлэлтийн чиглэлээр; (Хог ачилт хугацаандаа хийхгүй байна, хог хаягдлыг тогтсон хуваарийн дагуу ачуулах, орчны бохирдол эвгүй үнэр, золбин нохой муурын устгалын тухай) асуудлаар тус тус хандсан байна.

Сонгинохайрхан дүүрэгт хөдөө орон нутгаас шилжин ирж буй айл өрх, хүн ам нэмэгдэж, хог хаягдлын ачилтыг нэмэгдүүлэх шаардлага үүссэн энэ үед хог хаягдлыг ачих зориулалтын автомашинуудын насжилт өндөр, сэлбэг хэрэгсэл олдохгүй, шатахуун зарцуулалт их зэрэг хүндрэл бэрхшээл тулгарч байна.

Дээрх асуудлыг шийдвэрлэх, цэвэрлэгээ үйлчилгээний ажилчдын гар цэвэрлэгээний ажлыг хөнгөвчлөх, үр дүнтэй ажиллуулах зорилгоор хог хаягдлыг ачих зориулалттай тусгай тоног төхөөрөмж 2 автомашин, нийтийн эзэмшлийн зам талбайн автозамын шороог соруулах, шүүрдэх, усаар чийгшүүлэх зэрэг олон

үйлдэлт 2 автомашин, явган замын цас мөс дагтаршсан шороог хусаж түрэх зориулалтын мини автомат 14 төхөөрөмж зэрэг нийт 18 тусгай зориулалтын тоног төхөөрөмж бүхий автомашинуудыг хүлээлгэн өгч, ашиглаж байна.



Хог тээврийн менежментийг сайжруулах, үйлчилгээг эрчимжүүлэх зорилгоор 18, 24, 41 хороод, 21,31,43 хороод, 32, 33 хороо, 15, 11, 28 дугаар хороо, 16, 23, 30 дугаар хороо, 6, 17, 39 дүгээр хороо 38, 25, 42 дугаар хороодын хог хаягдлыг тээвэрлэх тендерийн урилгыг 4,650,856,230 төсөвтэй, 7 багцтайгаар 2025 оны 03 сарын 13-ны өдөр tender.gov.mn сайтад байршуулан зарлаж, 6 багц буюу 17 хороонд 6 хувийн хэвшлийн байгууллага шалгарч, хог тээвэрлэлтийн ажлыг 2025 оны 04, 05 дугаар сараас хийж эхэлсэн.

Дүүргийн Засаг даргын А/315 дугаар захирамжаар 18, 19, 27, 37 дугаар хорооны 5 байршилд далд бункерийн ажлыг “Дэд бүтцийн хөгжлийн алба” ОНӨААТҮГ-р гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж, ажил гүйцэтгэл шат дараалалтай хийгдэж байна.



Улаанчулуутын хогийн цэгийн орчим үүсмэл хогийн цэг үүссэн 5га газрыг “Тохижилт цэвэрлэгээ үйлчилгээ” ОНӨААТҮГ-р цэвэрлүүлэн, “Захиалагчийн ажлын алба” ОНӨААТҮГ-р торон хашаа хийлгэн тухайн газарт дахин хог асгуулахгүй байхаар 2 камер байршуулан камерын удирдлагын төвтэй хяналтыг холбосон. Мөн тухайн газарт дүүргийн сургууль, цэцэрлэг, эмнэлэг, төрийн байгууллагууд 10,000 мод тарьж, цаашдын арчилгаа усалгааг ТЦҮ-ОНӨААТҮГ хариуцан ажиллаж байна.

Иргэдийн ая тухтай эрүүл орчинд ажиллах, амьдрах нөхцөлийг сайжруулах зорилгоор дүүргийн нутаг дэвсгэрийн нийтийн эзэмшлийн зам талбай, гуу жалга, эзэнгүй талбайд үүссэн үүсмэл хогийн цэгийг цэвэрлүүлэх ажлыг зохион байгуулахаар дүүргийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 01-ны өдрийн А/167 дүгээр захирамжаар 43 хорооны 359 иргэдтэй хороодын Засаг дарга нар хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажиллуулж байна.

2025 онд хог тээвэр болон зам талбайн үйлчилгээнд 32 машин, тоног төхөөрөмжийг улс, нийслэл, дүүргийн 6,7 тэрбум төгрөгөөр парк шинэчлэлт хийсэн.

Ашиглалтын шаардлага хангахгүй болсон 25 машин техникийг актлуулсан. Хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр 18 дугаар хороонд газар доорх далд бункертэй ухаалаг хогийн савыг ашиглалтад оруулж, 4 хорооны 5 байршилд дээрх ажлыг нэмж хийж байна.

Дүүргийн 13 хорооны 38 байршилд үүссэн 13,5 мянган тонн үүсмэл болон хур хогийг цэвэрлэж, Нарангийн энгэрийн хогийн цэгт төвлөрүүлсэн. Мөн 22, 33 дугаар хорооны нийтийн эзэмшлийн талбайд олон жил хуримтлагдсан автомашины сэг хог хаягдлыг бүрэн цэвэрлэж 29 тн хогийг төвлөрсөн хогийн цэгт хүргүүлсэн.

Хороо бүрт иргэдийн бүлгийг байгуулж, 43 бүлгийн 359 иргэнтэй хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажиллуулж байна.

Үүсмэл болон хур хогийн цэг байнга үүсдэг цэгт 2024 онд 1,3 тэрбум төгрөгөөр хог хаягдлыг цэвэрлэх ажлыг хийсэн бөгөөд 2025 онд 8 хорооны 16 байршилд 48 хяналтын камерыг байршуулснаар хог хаях зөрчлийг бүрэн хянаж, хур хогийн цэвэрлэгээнд зарцуулдаг 1,0 тэрбум төгрөгийг хэмнээд байна.

2.5) Явган хүний зам, талбайн тохижилтын чиглэлээр;

(Явган хүний гарц, тэмдэг тэмдэглэгээ байхгүй байна, орц гарц гаргуулах тухай, явган хүний зам эвдрэлтэй байгаа тул засах өгөх, автобусны буудлын эвдрэл, тохижилтын тухай) хандсан байна. Дүүргийн хэмжээнд энэ чиглэлээр арга хэмжээ авч, сайжруулах чиглэлээр олон ажлууд хийгдсэн Үүнд:

Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн 313.1 сая төгрөгийн санхүүжилтээр 7, 8, 11 дүгээр хороодын нийтийн эзэмшлийн талбайд 1547 м² явган зам, дүүргийн төсвийн хот тохижуулах зардлын 377.2 сая төгрөгийн хөрөнгөөр 27, 29 дүгээр хороодын нутаг дэвсгэрт 2050 м² талбайд явган хүний замыг шинээр хийж гүйцэтгэн иргэдийн аюулгүй орчныг бүрдүүлэн ажилласан.

Байр, хороолол дундах нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт, хүүхдийн тоглоомын талбай, авто зогсоолын бүтээн байгуулалтын ажлуудын хүрээнд 3694м² явган зам шинээр хийгдсэн.

Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 8 хорооны (8, 15, 18, 20, 25, 27, 35, 43) нутаг дэвсгэрт нарийн гудамжинд 1410 м² явган хүний замыг хуучин хавтангаар хийж тохижуулсан.

НЗД-ын А/560 дугаар захирамж, нийслэлийн хот тохижилтын бусад зардлаас 2,150,0 сая төгрөгийн санхүүжилтээр 88 байршилд тохижилтын ажил хийж гүйцэтгэснээс 13 байршилд 2492м² явган замын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Дүүргийн төсвийн хөрөнгөөр 32, 35 дугаар хорооны нутаг дэвсгэрт иж бүрэн зам төслийн хүрээнд Хурганы зам 2,68км, Нарангийн голын авто замаас 35 дугаар хорооны байр хүртэлх 1,4 км авто замуудын ажлын хүрээнд 12,240м² явган зам ашиглалтад оруулсан. Нийт 24,872м² явган зам хийгдсэн.





Дүүргийн захын гэр хороололд автобус цөөн тоогоор ирдэг болон иргэд удаан хугацаагаар автобус хүлээдэг 1, 11, 26, 33, 36 дугаар хороодод дулаан автобусны буудлыг үе шаттайгаар байршуулж, 17 дугаар хорооны нутаг дэвсгэрт нийт 24 байршилд дулаан автобусны буудал байршуулаад байна.



Гурав. Өргөдөл, гомдлын зөрчлийг бууруулж, шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр:

- Өргөдөл, гомдлыг бууруулах чиглэлээр Засаг даргын Тамгын газар нь “TelcoCom” үүлэн технологид суурилсан харилцаа холбооны үйлчилгээг 2024 оны 11 дүгээр сард нэвтрүүлсэн. 2024 оны байдлаар цахим системээр нийт 5700 өргөдөл, гомдол ирсэн бол энэ онд 4587 буюу өргөдлийн тоо 20 хувиар буурсан үзүүлэлтэй байна. Тус үйлчилгээг нэвтрүүлсэн хугацаанд иргэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай авч, өргөдөл, гомдлын тоо буурсан байна. Мөн төрийн байгууллагын хүнд суртал, дараалал чирэгдэл багасахаас гадна хэлтэс, тасагт ирсэн дуудлагын тоо мэдээ, дуут бичлэг, тайлан үр дүнг тооцох олон давуу талуудтай байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг сайжруулах 3 зорилт, 10 арга хэмжээтэй тусгай төлөвлөгөөг батлуулж биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргаж 98,4 хувийн гүйцэтгэлтэй байна.
- Дүүргийн харьяа байгууллагуудад жилийн эцсийн байдлаар нийт 3307 өргөдөл, гомдол ирснээс шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр харьяа байгууллагуудад Засаг даргын Тамгын газрын 03/276, 03/475, 03/770, 03/1200, 03/1201, 03/1212, 03/1213, 03/2324, 03/2680, 03/2690-2694, 03/2698-

2704, 03/2771, 03/3388 дугаартай 13 удаагийн зөвлөмж, чиглэлийг тус тус хүргүүлсэн. Зөвлөмжийн дагуу холбогдох хэлтэс, алба зөрчлийг бууруулж удаа дараа хандаж байгаа иргэдийн тоо өмнөх оны мөн энэ үеэс 26 хувиар буурсан үзүүлэлтэй байна.

- Дүүргийн эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын удирдлагын гүйцэтгэлийг тайланг үнэлэх ажлын хүрээнд өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хуулийн хугацаа хэтэрсэн болон зөрчлийн тоо мэдээг гаргаж, үр дүнг тооцуулсан.
- Нийслэлийн Засаг даргын даргын 01, 07 дугаар хуралдааны тэмдэглэлээр ирүүлсэн үүрэг даалгаврын хүрээнд байгууллагын албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэхдээ өргөдөл, гомдлын болон хариутай албан бичгийн шийдвэрлэлтийг харгалзан үзэж үр дүнг тооцсон. Засаг даргын Тамгын газарт 3-с дээш зөрчил гаргасан 2 албан хаагч, хуулийн хугацаа хэтрүүлсэн 1 албан хаагчийн тайлангийн үнэлгээнээс бууруулж арга хэмжээ авсан.
- Төрийн байгууллагын хүнд суртал, сахилга хариуцлагыг дээшлүүлэхээр өргөдөл, гомдлыг шийдвэрлэх явцад зөрчил дутагдал гаргасан 9 байгууллагын 7 нь албан хаагчдад анхааруулга өгч, 2 албан тушаалтанд Төрийн албаны тухай хуулийн дагуу сахилгын шийтгэл ноогдуулж, хариуцлага тооцсон. Дүүргийн хэмжээнд хуулийн хугацаа хэтэрч шийдвэрлэсэн 4 өргөдөл бүртгэгдсэнээс өмнөх оны мөн энэ үетэй харьцуулахад 9 буюу 55 хувиар буурсан байна.
- Дүүргийн 43 хорооны Зохион байгуулагч, Нийгмийн ажилтан нарт өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, тогтоомж болон өргөдлийг бүртгэх, шийдвэрлэх, системийг ашиглах арга зүйн сургалтыг зохион байгуулсан.
- Засаг даргын зөвлөлийн хурал болон удирдах албан тушаалтнуудын шуурхайн хуралд өргөдөл, гомдлыг шийдвэрлэлтийн явц, мэдээг 5 удаа танилцуулж, үр дүнг тооцон чиглэл хүргүүлсэн. (Зөвлөлийн хурлын төлөвлөгөө, албан хаагчдын хуралдааны тэмдэглэлийг хавсаргав)
- Засаг даргын Тамгын газарт ирсэн саналын шинжтэй өргөдлийг бүртгэж, байгууллагын бодлого үйл ажиллагаанд тусгуулахаар саналыг холбогдох хэлтэс тасагт хүргүүлсэн. Мөн удаа дараа хандсан иргэдийн гомдолд дүн шинжилгээ хийж иргэнд хариуг эцэслэн шийдвэрлэж хүргүүлэх ажлыг зохион байгуулж, арга хэмжээ авч ажилласан.

- Дүүргийн “Shd.ub.gov.mn” цахим хуудсанд өргөдөл, гомдлын мэдээ, тайланг улирал бүр оруулж, ил тод байршуулсан.
- Байгууллагын өргөдөл, гомдол хариуцсан мэргэжилтэн чиг үүргийн дагуу өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд өдөр тутам хяналт тавьж, харьяа байгууллагууд, хороодод шаардлагатай заавар зөвлөгөө өгч, арга зүйгээр хангаж ажилласан.

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
ДАРГА  А.БЯМБА

ТАЙЛАН ГАРГАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН  Б.НОМИН-ЭРДЭНЭ



